



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/267

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар шийдвэрийн 6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд олон нийтийн болон нийтийн эзэмшлийн зам талбай, байрнуудын орц, айл өрхүүд, хог хаягдлын цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлт хийх ариутгалын бодис худалдан авахад 5930.0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2.Тус арга хэмжээнд зарцуулах 5930.0 мянган төгрөг /Таван сая есөн зуун гучин мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.12-д баталсан “Эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах” хөтөлбөрийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
05 дугаар сарын 08-ны өдрийн  
А/267 дугаар захирамжийн хавсралт



АРИУТГАЛЫН БОДИС ХУДАЛДАН АВАХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

дд	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1.	Жавелион	Ширхэг	40	80000.00	3200.0
2.	Жилью	Ширхэг	70	39000.00	2730.0
					5930.0

-oOo-